



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СНА-2024/62/НА-СТА-ТӨА

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он</p>	<p>Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Д.Энхдалай Утас: 51-261628 Цахим хаяг: enkhdalai.d@audit.mn Ахлах аудитор: А.Даваадорж Утас: 51-261740 Цахим хаяг: davaadorja@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Аав ээжийн тэнгэрлэг буян Аудит ХХК Захирал: О.Бурмаа Цахим хаяг: aetb.audit@gmail.com 99168735</p>
---	---



БУЯНТ УХАА СПОРТЫН ОРДОН
ТӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ Л.ЭНХБАЯР
ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.03.25 № 07/786
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын 2023 оны 9 дүгээр сарын 30-ны өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын 2023 оны 9 дүгээр сарын 30-ны өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн авлага, өр төлбөрийг харилцагчтай тооцоо нийлж баталгаажуулаагүй, бараа материалын үлдэгдэлд эд хөрөнгийн тооллого хийгээгүй, анхан шатны бүрдэл дутуу баримтыг үндэслэн ажил гүйлгээг бүртгэлд тусгасан нийт 391.3 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан, дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.1.4, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 -д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын тохиолдсон байх, тасалбар болголт, үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ нь биеийн тамир, спортын талаар төрөөс явуулж буй бодлогын хэрэгжилтийг хангах, төрөөс баримтлах бодлогод тусгасан зорилгыг хэрэгжүүлэх, иргэдийн дунд нийтийг хамарсан биеийн тамир, спорт, чийрэгжилтийн арга хэмжээ болон олон улс, тив, дэлхийн тэмцээнийг зохион байгуулах, соёл урлагийн болон бусад арга хэмжээг зохион байгуулахад чиглэсэн үйлчилгээ үзүүлэх

зорилго бүхий өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар үйл ажиллагаа явуулсан байна.

Аудитын гол асуудал

Монгол Улсын талаас Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, БНХАУ-ын талаас Худалдааны Яамны Олон улсын эдийн засаг хамтын ажиллагааны Хэрэг эрхлэх газар харилцан тохиролцож, Буянт-Ухаа спортын ордны засвар үйлчилгээний төслийг хэрэгжүүлэхээр 2019 оны 8 дугаар сарын 29-ний өдөр гэрээ байгуулсан.

Энэ гэрээний хүрээнд Буянт-Ухаа спортын ордны засвар үйлчилгээний төслийн ажил 2022 оны 6 дугаар сард эхэлсэн байна.

Төслийн ажил дуусаж БНХАУ-ын талын хүсэлтийн дагуу Ордны барилга, байгууламжийг Монгол талын Төслийн хэрэгжүүлэлтийн нэгжид хүлээлгэн өгч улмаар Зүүн Азийн залуучуудын II наадмын волейболын тэмцээн 2023 оны 8 дугаар сарын 16-наас 23-ны өдрүүдэд зохион байгуулагдсан байна.

Ордны засвар үйлчилгээний төслийг хэрэгжүүлэх гэрээний дагуу Засгийн газрын нөөц сангаас 796.9 сая төгрөг олгохоос тайлант онд 159.4 сая төгрөгийн санхүүжилт авч, ордны гадна авто замд орсон холболтын кабелийн хучилтын ажлын төлбөрт 28.8 сая, кабелийн угсралт, холболтын зардалд 54.3 сая, ажлын хөлсөнд 9.8 сая төгрөгийг гүйцэтгэгчид шилжүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Ордны засвар, үйлчилгээний төслийн ажил хийгдэж байгаатай холбоотойгоор тус байгууллагын 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө батлагдаагүй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 9 дүгээр сарын 30-ны өдрөөр дуусвар болсон

№	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2022 оны 12-р сарын 31	2023 оны 9-р сарын 30
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	37,309,421.21	38,099,235.13
1.1.2	Дансны авлага	55,380,658.54	42,342,853.25
1.1.3	Татвар, НДШ - ийн авлага	-	80,813.30
1.1.4	Бусад авлага	5,307,743.20	12,784,147.17
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	68,742,567.57	44,715,693.76
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	367,765,207.10	614,301,909.93
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	534,505,597.62	752,324,652.54
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	46,492,314,308.22	46,492,314,308.22
1.2.2	Биет бус хөрөнгө	461,447,083.58	460,537,083.58
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	29,268,393.00	29,268,393.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	46,983,029,784.79	46,982,119,784.79
1.3	Нийт хөрөнгийн дүн	47,517,535,382.41	47,734,444,437.33
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
2.1.1.1	Дансны өглөг	58,138,474.27	18,570,925.27
2.1.1.2	Цалингийн өглөг	-	-
2.1.1.3	Татварын өр	136,529,617.07	135,824,448.96
2.1.1.4	НДШ - ийн өглөг	49,118,994.05	
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	27,377,072.73	165,500,000.00
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	271,164,158.12	319,895,374.23
2.1.2	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	271,164,158.12	319,895,374.23
2.3	ЭЗДИЙН ӨМЧ		
2.3.1	-төрийн	29,408,582,053.34	29,408,582,053.34
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	25,938,458,763.97	25,938,458,763.97
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	825,714,247.40	985,082,626.40
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(8,926,383,840.41)	(8,917,574,380.21)
2.3.11	Эздийн өмчийн дүн	47,246,371,224.30	47,414,549,063.10
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	47,517,535,382.41	47,734,444,437.33

Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 9 дүгээр сарын 30-ны өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 09-р сарын 30
1	Борлуулалтын орлого (цэвэр)	259,580,081.91	231,076,029.83
2	Борлуулалтын өртөг	215,534,699.66	
3	Нийт ашиг (алдагдал)	44,045,382.25	
4	Үйлчилгээний орлого	7,218,181.82	159,116,680.32
5	Хүүгийн орлого	-	-
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Гэрээний орлого	-	74,804,545.45
8	Бусад орлого	159,865,909.09	164,783.06
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	382,779,787.97	220,337,976.73
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	2,510,000.00	
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(174,160,314.82)	13,748,032.10
19	Орлогын татварын зардал	-	161,166.92
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(174,160,314.82)	13,586,865.18
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(174,160,314.82)	13,586,865.18
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн		
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 9 дүгээр сарын 31-ны өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2022 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	29,408,582,053.34	25,938,458,763.97	825,714,247.40	(8,926,383,840.39)	47,246,371,224.30
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(4,777,405.00)	(4,777,405.00)
Залруулсан үлдэгдэл					
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	13,586,865.18	13,586,865.18
Өмчид гарсан өөрчлөлт			159,368,378.60		159,368,378.60
2023 оны 09-р сарын 30-ны үлдэгдэл	29,408,582,053.34	25,938,458,763.97	985,082,626.00	(8,917,574,380.21)	47,414,549,063.10

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 9 дүгээр сарын 30-ны өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 9-р сарын 30
1.1	Мөнгөн орлогын дүн	403,931,449.00	442,025,698.22
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	217,161,089.00	252,801,542.62
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	2,342,627.00	
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	177,502,733.00	189,018,685.60
1.1.6	Бусад мөнгөн орлого	6,925,000.00	205,470.00
1.2	Мөнгөн зарлагын дүн	403,543,858.76	449,076,940.36
1.2.1	Ажиллагчдад төлсөн	152,961,889.32	133,092,726.20
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	689,001.56	87,911,896.40
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	47,426,363.08	194,152,905.76
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	43,746,275.95	27,603,008.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	28,641,576.50	352,500.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	4,957,227.67	230,404.00
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	-	-
1.2.9	Бусад мөнгөн зарлага	125,121,524.68	5,733,500.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	387,590.24	(7,051,242.14)
2.1	Мөнгөн орлогын дүн	3,931,846.00	-
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	3,931,846.00	-
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	-	-
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн	2,864,000.00	-
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	910,000.00	
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	1,954,000.00	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,067,846.00	
3.1	Мөнгөн орлогын дүн	49,140,000.00	
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	49,140,000.00	
3.1.3	Төрөл бүрийн хандив	-	
3.2	Мөнгөн зарлагын дүн	49,140,000.00	7,841,056.06
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	49,140,000.00	7,841,056.06
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	(7,841,056.06)
4	Валютын ханшийн зөрүү	-	-
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,455,436.24	789,813.92
5	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	35,853,984.97	37,309,421.21
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	37,309,421.21	38,099,235.13

Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 30,491.3 сая төгрөгийн 2 алдаа¹ илэрснийг санхүүгийн тайланд залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Санхүүгийн тайлангийн эхний үлдэгдлийг аудитын өмнөх оны тайлантай тулгахад хөрөнгө, өр төлбөр, өмчийн дүнг зөрүүтэй тайлагнасан.	1	30,257,238.2			1	30,257,238.2	1	30,257,238.2				
2	Санхүүгийн тайлан дахь борлуулалтын орлогыг ерөнхий журнал, ерөнхий дэвтрийн орлогын дүнгээс зөрүүтэй тайлагнасан.	1	243,030.6			1	243,030.6	1	243,030.6				
	Дүн	2	30,491,268.8			2	30,491,268.8	2	30,491,268.8				

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

Аудитаар нийт 391.3 сая төгрөгийн зөрчил илэрч зөрчлийг арилгах 7 албан шаардлага хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг санхүүгийн тайланд бүртгэсэн	1	64,234.4			1	64,234.4						
2	Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй	1	71,275.7			1	71,275.7						
3	Бараа материалын тайлангаар зарцуулалтын анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийж бүртгэлд тусгасан	1	19,725.9			1	19,725.9						
4	Эхний хагас жилийн байдлаар бараа материалын үлдэгдэлд эд хөрөнгийн тооллого хийгээгүй	1	44,715.7			1	44,715.7						
5	Нэмэгдсэн өртгийн албан татварын үлдэгдэл санхүүгийн тайланд дутуу тайлагнасан	1	19,680.4			1	19,680.4						
6	Өглөгийн дансны үлдэгдэл тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй	1	171,689.8			1	171,689.8						
	Дүн	6	391,321.8			6	391,321.8						

Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 629.6 сая төгрөгийн зөрчил илэрч 2 албан шаардлага хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
1	Шилэн дансны цахим хуудсанд 48 мэдээллийг байршуулаагүй, мөн цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 29 гүйлгээнээс орлогын 332,756.3, мянган төгрөгийн, зарлагын 177,311.8 мянган төгрөгийн мэдээллийг байршуулаагүй	1	510,068.1			1	510,068.1		
	Дүн	1	510,068.1			1	510,068.1		
	Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
2	Өмнөх аудитаас өгсөн 2 зөвлөмж, 5 албан шаардлага, 1 актын хэрэгжилт хангалтгүй	1	119,567.9			1	119,567.9		
	Дүн	1	119,567.9			1	119,567.9		
	Нийт дүн	2	629,636.0			2	629,636.0		